



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2017 оны 9 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэр, улсын төсвийн хөрөнгөөр ирэх төсвийн жилүүдэд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай:

Ахлагч: -Сангийн дэд сайд

Гишүүд: -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан дэд дарга;

-Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга;

-Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга;

-Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга;

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Олон улсын төсөл, хөтөлбөр, гадаад хамтын ажиллагааны газрын дарга;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга;

-Эрчим хүчний яамны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга;

-Сангийн сайдын зөвлөх;


-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

-Нийслэлийн газрын албаны дарга.

Нарийн бичгийн
дарга:

-Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн;

-Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын мэргэжилтэн.



Монгол Улсын Ерөнхий сайдын
үүрэг гүйцэтгэгч

Ж.ЭРДЭНЭБАТ

